



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТШИРЭЭТ СУМЫН “БАТШИРЭЭТ” СУМ  
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар A/43.

Батширээт сум

Тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.4 дахь заалт, 73 дугаар зүйлийн 73.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын 2025 оны жилийн эцсийн тооллогын комиссыг доорхи гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үүнд: Комиссын дарга: Б. Батчимэг / Ерөнхий инженер /

Гишүүд: Б. Дуламжав / Ойн техникч /

Г. Ганзолбоо / Жолооч /

1. Эд хөрөнгийн тооллогын ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг тооллогын комисст үүрэг болгосугай.



ДАРГА *[Signature]* АНТУЯА

Байгууллагын 2025 оны сүүлийн хагас жилийн эд хөрөнгийн тооллогын

коммиссын хурлын тэмдэглэл

№ 01

2025.12.25

Батширээт сум

Комиссын хурал 2025 оны 12 дугаар сарын 25-ны өглөө 10:00 цагт эхлэн 100% ирцтэй буюу комиссын гишүүд бүгд хамрагдан хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Хурлыг тооллогын комиссын дарга Б. Батчимэг удирдан явуулав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Тооллого явуулах ажлын төлөвлөгөө хэлэлцэн батлах
2. Байгууллагын 2025 оны сүүлийн хагас жилийн эд хөрөнгийн тооллого явуулах

СОНССОН НЬ: Комиссын дарга Б. Батчимэг

Батширээт СДОАнгийн Даргын 2025 оны 12 дугаар сарын 25 -ны өдрийн А/43 тоот тушаалын дагуу тооллогын комиссын бүрэлдэхүүнийг дараах гишүүдийн бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Комиссын ахлагч: Ерөнхий инженер – Б. Батчимэг

Гишүүд: Ойн техникч – Б. Дуламжав

Жолооч – Г. Ганзолбоо нарыг томилсон тушаалыг

уншиж танилцуулав.

Комисс ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэж төлөвлөгөөг батлав.

Ажлын төлөвлөгөө

№	Тооллого хийх ажил	хугацаа	Хариуцах эзэн
1	Ажилчин албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийг картын дагуу тоолох, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг шалгах	2025.12.25	Комиссын гишүүд
2	Агуулахын эд хөрөнгийг тоолох	2025.12.26	Комиссын гишүүд
3	Техник хэрэгслийг тоолох, бүрэн бүтэн байдлыг хянаж тоолох	2025.12.26	Комиссын гишүүд
4	2-р хурал зохион байгуулах	2025.12.29	Комиссын гишүүд
5	Тооллогын дүнг нэгтгэж даргад танилцуулах	2025.12.29	Комиссын гишүүд

Ажлын төлөвлөгөөг санал нэгтэй баталлаа.

Шийдвэрлэсэн нь: Комиссын гишүүд ажлын төлөвлөгөөний дагуу ажиллах, эд хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулах.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: Нярав, бичиг хэрэг *Г. Солонго* Б. Солонго

Хурлын тэмдэглэлтэй танилцсан: Комиссын дарга: *Б. Батчимэг* Б. Батчимэг

Гишүүд: *Б. Дуламжав* Б. Дуламжав

*Г. Ганзолбоо* Г. Ганзолбоо

Байгууллагын 2025 оны сүүлийн хагас жилийн эд хөрөнгийн тооллогын  
комиссын хурлын тэмдэглэл

№ 02

2025.12.30

Батширээт сум

Комиссын хурал 2025 оны 12 дугаар сарын 30 -ны өдөр 14:00 цагт эхлэн 100% ирцтэй буюу комиссын гишүүд бүгд хамрагдан хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ: Хурлыг тооллогын комиссын дарга Б. Батчимэг удирдан явуулав.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Тооллогын дүнг нэгтгэн танилцуулах .

СОНССОН НЬ: Комиссын дарга Б. Батчимэг

Батширээт СДОАнгийн Даргын 2025 оны 12 дугаар сарын 25 -ны өдрийн А/43 тоот тушаалын дагуу тооллогын комиссын бүрэн бүрэлдэхүүнээр байгууллагын эд хөрөнгийн тооллогыг 2025 оны 12 дугаар сарын 25-наас 30 -ны өдрүүдэд чанартай зохион байгууллаа. Тооллого хийж байх үед Батширээт СДОАнгийн 1га мод үржүүлгийн талбайн газар үндсэн хөрөнгөд бүртгэлгүй байна. Батширээт сумын газрын даамал Д.Батчимэг газрын программын шинэчлэлтэй холбоотойгоор цахимд бүртгээгүй тул үндсэн хөрөнгөөр бүртгэлд авах боломжгүй байна. Хэнтий аймгийн орон нутгийн өмчийн газраас үндсэн хөрөнгөд бүртгэж авах хүсэлтээ албан бичгээр ирүүл гэсэн ч 2025 ондоо бүртгэх боломжгүй байна. Өөр ямар нэгэн зөрчил, дутагдал илэрсэнгүй.

Комиссын гишүүн: Б. Дуламжав, Г. Ганзолбоо

Үндсэн хөрөнгө болон техник тоног төхөөрөмжийг тоолж дуусгалаа.

Комиссын тооллогын ажлыг санал нэгтэй хаав.

Шийдвэрлэсэн нь:

Үндсэн хөрөнгө болон техник тоног төхөөрөмжийг тоолж дуусгалаа. Тооллогоор гарсан зөрчил болох мод үржүүлгийн талбайн газрыг яаралтай газрын даамалд хандан шийдвэрлүүлж үндсэн хөрөнгөд бүртгэх шаардлагатай.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: Нярав, Бичиг хэрэг *Б. Солонго* Б. Солонго

Хурлын тэмдэглэлтэй танилцсан: Комиссын дарга: *Б. Батчимэг* Б. Батчимэг

Гишүүд: *Б. Дуламжав* Б. Дуламжав  
*Г. Ганзолбоо* Г. Ганзолбоо